

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: oyun-erdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит
ХХК Утас: 77233030
Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.БОЛОРМАА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ны өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмж орон нутгийн нэмэгдлийг албан хаагчдад 40 хувиар олгох болсонтой холбоотой цалингийн зардал өмнөх оноос 287.2 сая төгрөгөөр өссөн байна

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль нь 1 хөтөлбөр, 18 арга хэмжээний гүйцэтгэл 88.5 хувьтай, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд

4825020257

тусгасан 4 зорилтын хүрээнд 31 ажлыг төлөвлөж, Боловсролын газраас гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 92.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>134,299,808.72</u>	<u>318,714,406.27</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	32,064,283.54	170,977,828.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,064,283.54	170,977,828.65
3121	Төгрөг	32,064,283.54	170,977,828.65
31211	Төрийн сангийн харилцах	23,172,410.54	155,745,955.65
31218	Ахмадын сангийн харилцах	8,891,873.00	15,231,873.00
33	АВЛАГА	1,000,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,000,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	101,235,525.18	147,736,577.62
351	Түүхий эд материал	65,232,539.68	105,379,948.12
35110	Тусгай зориулалттай материал	63,925,039.68	104,072,448.12
35130	Эм боох материал	1,307,500.00	1,307,500.00
354	Хангамжийн материал	33,742,985.50	40,426,629.50
35410	Бичиг хэргийн материал	4,272,950.00	4,274,950.00
35420	Аж ахуйн материал	12,170,761.00	13,618,581.00
35440	Түлш, шатах тослох материал	2,400,000.00	2,675,400.00
35450	Барилгын засварын материал	12,274,448.50	10,834,948.50
35460	Хүнсний материал	2,624,826.00	9,022,750.00
35600	Мал амьтад	2,260,000.00	1,930,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,802,080,924.03</u>	<u>1,914,289,068.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,802,080,924.03	1,914,289,068.76
392	Биет хөрөнгө	1,754,184,524.03	1,866,392,668.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,607,070,335.16	1,607,070,335.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(94,652,443.63)	(122,329,974.79)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,500,000.00	35,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,494,444.38)	(9,861,111.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,538,082.47	268,897,372.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,185,139.96)	(64,743,307.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,544,648.00	96,539,447.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,247,794.19)	(13,969,610.03)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	62,894,800.00	62,894,800.00
39217	Ном	5,216,480.56	6,394,717.06
393	Биет бус хөрөнгө	47,896,400.00	47,896,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,896,400.00	47,896,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,936,380,732.75</u>	<u>2,233,003,475.03</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>15,145,855.28</u>	<u>26,187,806.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,145,855.28	26,187,806.00
413	Өглөг	15,145,855.28	26,187,806.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	60,839.28	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,603,306.00	11,668,806.00
4136	Бусад өглөг	2,481,710.00	14,519,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,481,710.00	14,519,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,921,234,877.47</u>	<u>2,206,815,669.03</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,921,234,877.47	2,206,815,669.03

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	932,879,876.77	932,879,876.77
51101	Өмч: - төрийн	932,879,876.77	932,879,876.77
512	Хуримтлагдсан үр дүн	172,771,888.62	458,352,680.18
51210	Өмнөх үеийн үр дүн	172,771,888.62	172,771,888.62
51220	Тайлант үеийн үр дүн	-	285,580,791.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	815,583,112.08	815,583,112.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,936,380,732.75</u>	<u>2,233,003,475.03</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,101,520,580.76	1,585,699,196.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	237,655,080.76	238,951,896.41
120	Нийтлэг татварын бус орлого	237,655,080.76	238,951,896.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,354,398.00	29,349,645.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,022,000.00	808,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,332,398.00	28,541,445.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	186,362,572.76	168,055,636.97
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	33,938,110.00	41,546,614.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	863,865,500.00	1,346,747,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	738,108,600.00	1,189,253,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	738,108,600.00	1,189,253,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,756,900.00	157,494,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,756,900.00	157,494,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	957,776,679.25	1,297,858,404.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	957,776,679.25	1,297,858,404.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	942,401,239.28	1,295,481,113.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,588,331.28	858,801,236.63
210101	Үндсэн цалин	422,665,080.00	548,945,633.00
210102	Нэмэгдэл	125,742,871.28	272,709,243.63
210104	Урамшуулал	23,180,380.00	37,146,360.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,646,956.57	101,035,822.89
210201	Тэтгэврийн даатгал	48,697,275.01	66,935,346.69
210202	Тэтгэмжийн даатгал	5,732,191.96	8,882,989.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,519,753.51	4,761,123.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,049,674.35	4,009,389.04
210205	Эрүүл мэндийн даатгал	10,648,061.74	16,446,974.30

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,090,959.03	145,713,408.90
210301	Гэрэл, цахилгаан	7,953,520.03	9,885,493.90
210302	Түлш, халаалт	114,137,439.00	129,827,915.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,810,477.80	12,339,833.00
210401	Бичиг хэрэг	2,347,534.00	4,923,183.00
210402	Тээвэр, шатахуун	3,113,050.00	5,202,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,889,690.00	2,214,350.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	7,460,203.80	-
2105	Нормативт зардал	44,549,075.00	61,253,806.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	220,400.00	154,400.00
210502	Хоол, хүнс	44,328,675.00	61,099,406.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,958,500.00	15,081,900.00
210604	Урсгал засвар	9,958,500.00	15,081,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,864,400.00	8,681,213.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,022,000.00	808,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,842,400.00	7,873,013.09
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,892,539.60	92,573,893.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,822,160.00	9,281,901.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,492,400.00	2,485,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,577,979.60	80,806,292.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,375,439.97	2,377,291.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,480,960.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,480,960.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,894,479.97	2,377,291.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,894,479.97	2,377,291.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>143,743,901.51</u>	<u>287,840,791.56</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,326,105.10	2,260,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	20,326,105.10	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	2,260,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(20,326,105.10)	(2,260,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>123,417,796.41</u>	<u>285,580,791.56</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>881,109,898.00</u>	<u>1,376,096,945.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>17,244,398.00</u>	<u>29,349,645.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	17,244,398.00	29,349,645.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,244,398.00	29,349,645.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,022,000.00	808,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,222,398.00	28,541,445.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	863,865,500.00	1,346,747,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	738,108,600.00	1,189,253,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	738,108,600.00	1,189,253,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	125,756,900.00	157,494,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,756,900.00	157,494,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>847,966,234.05</u>	<u>1,226,743,599.89</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	847,966,234.05	1,226,743,599.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	821,695,236.08	1,198,294,878.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	574,317,094.29	857,862,075.91
210101	Үндсэн цалин	390,862,626.55	548,006,472.28
210102	Нэмэгдэл	157,970,820.96	272,709,243.63
210104	Урамшуулал	25,483,646.78	37,146,360.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,877,128.76	101,035,822.89
210201	Тэтгэврийн даатгал	48,722,362.82	66,953,903.16
210202	Тэтгэмжийн даатгал	5,196,465.14	8,878,350.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,131,052.44	4,852,200.80
210204	Ажилгүйдлийн даатгал	976,718.31	3,983,720.29
210205	Эрүүл мэндийн даатгал	9,850,530.05	16,367,648.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,784,120.03	146,313,408.90
210301	Гэрэл, цахилгаан	7,953,520.03	9,885,493.90
210302	Түлш, халаалт	106,830,600.00	130,427,915.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2105	Нормативт зардал	27,095,993.00	37,902,380.00
210502	Хоол, хүнс	27,095,993.00	37,902,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,099,100.00	12,310,300.00
210604	Урсгал засвар	6,099,100.00	12,310,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,014,400.00	11,202,923.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,022,000.00	808,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,992,400.00	10,394,723.09
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,507,400.00	31,667,968.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,015,000.00	28,215,868.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,492,400.00	3,452,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,270,997.97	28,448,721.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,376,518.00	26,071,430.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,376,518.00	26,071,430.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,894,479.97	2,377,291.10

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,894,479.97	2,377,291.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33,143,663.95</u>	<u>149,353,345.11</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,140,000.00	10,439,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,140,000.00	10,439,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,140,000.00	10,439,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,140,000.00	10,439,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,140,000.00)</u>	<u>(10,439,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,003,663.95	138,913,545.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,060,619.59	32,064,283.54
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,064,283.54	170,977,828.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	932,879,876.77	815,583,112.08	52,179,298.49	1,800,642,287.34
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	932,879,876.77	815,583,112.08	52,179,298.49	1,800,642,287.34
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	120,592,590.13	120,592,590.13
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	932,879,876.77	815,583,112.08	172,771,888.62	1,921,234,877.47
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	932,879,876.77	815,583,112.08	172,771,888.62	1,921,234,877.47
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	932,879,876.77	815,583,112.08	172,771,888.62	1,921,234,877.47
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	285,580,791.56	285,580,791.56
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	932,879,876.77	815,583,112.08	458,352,680.18	2,206,815,669.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,391,445,900.00	1,231,406,108.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,391,445,900.00	1,231,406,108.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,365,095,600.00	1,205,056,178.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	977,481,800.00	857,218,629.91
210101	Үндсэн цалин	659,124,500.00	547,363,026.28
210102	Нэмэгдэл	302,351,100.00	272,709,243.63
210104	Урамшуулал	16,006,200.00	37,146,360.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,185,400.00	101,679,268.89
210201	Тэтгэврийн даатгал	83,086,000.00	67,597,349.16
210202	Тэтгэмжийн даатгал	9,774,900.00	8,878,350.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,887,400.00	4,820,415.03
210204	Ажилгүйдлийн даатгал	4,887,400.00	4,015,506.06
210205	Эрүүл мэндийн даатгал	19,549,700.00	16,367,648.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,690,700.00	146,313,408.90
210301	Гэрэл, цахилгаан	9,926,300.00	9,885,493.90
210302	Түлш, халаалт	132,764,400.00	130,427,915.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2105	Нормативт зардал	37,624,000.00	37,623,880.00
210502	Хоол, хүнс	37,624,000.00	37,623,880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,803,300.00	12,310,300.00
210604	Урсгал засвар	12,803,300.00	12,310,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,273,200.00	12,202,923.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	808,200.00	808,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,465,000.00	11,394,723.09
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,037,200.00	37,707,768.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,874,700.00	32,545,568.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,162,500.00	5,162,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,350,300.00	26,349,930.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,350,300.00	26,349,930.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,350,300.00	26,349,930.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,391,445,900.00	1,363,979,653.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,189,253,300.00	1,189,253,300.00
122005	Улсын төсвөөс санхүүжих	1,189,253,300.00	1,189,253,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	157,494,000.00	155,116,708.90

132001	Орон нутгийн төсвөөс	157,494,000.00	155,116,708.90
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	44,698,600.00	19,609,645.00
120010	Туслах үйл ажиллагааны орлого	21,600,000.00	19,609,645.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	23,098,600.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	23,172,410.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	155,745,955.65

Гурав. Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж/

Аудитаар нийт 225,465.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 15,519.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 172.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 209,773.7 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлжээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 15,519.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

Зээлээр авсан интернэт холболтын 15,519.0 мянган төгрөгийн төхөөрөмжийг орлого авч бүртгэл тайланд тусгаагүй.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 209,946.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 172.4 мянган төгрөгийн акт тогтоож, 209,773.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

Багш ажилчдад цалин хөлсийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжтэй давхардуулан олгосон. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, НББТХ-ийн 13.1-т /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/ заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

3.2.1 Тоног төхөөрөмжийн шинэчлэлээр ашиглагдахгүй болсон 5,319.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан. /3 ширхэг халаалтын зуух/ Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. *Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах* гэснийг зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлөөр асуудлийг хуулийн дагуу шийдвэрлүүлэх;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2.2 Агуулахын зориулалтаар ашиглаж байгаа 62,894.8 мянган төгрөгийн барилгыг дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэж тайлагнасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл. */Төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх, бүртгэх/25.1-т /Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ/* заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлөөр асуудлийг хуулийн дагуу шийдвэрлүүлэх.

3.2.3 Байгууллагын дансанд бүртгэлтэй боловч ашигладаггүй, ашиглах боломжгүй хөдөөгийн багт байршилтай 141,559.9 мянган төгрөгийн конторын барилгын эзэмшил, бүртгэлийн асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. 31.3-т */Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах/* заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлөөр асуудлыг шийдвэрлүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зээлээр авсан интернэт холболтын төхөөрөмжийг орлого авч бүртгэл тайланд тусгаагүй.	1	15,519.0	1	15,519.0			1	15,519.0				
Дүн	1	15,519.0	1	15,519.0			1	15,519.0			-	-

2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Багш ажилчдад цалин хөлсийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжтэй давхардуулан олгосон.	1	172.4	1	172.4								
Тоног төхөөрөмжийн шинэчлэлээр ашиглагдахгүй болсон үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан. /3 ширхэг халаалтын зуух/	1	5,319.0					1	5,319.0				
Агуулахын зориулалтаар ашиглаж байгаа барилгыг дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэж тайлагнасан.	1	62,894.8					1	62,894.8				

Байгууллагын дансанд бүртгэлтэй боловч ашигладаггүй, ашиглах боломжгүй хөдөөгийн багт байршилтай конторын барилгын эзэмшил, бүртгэлийн асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй.	1	141,559.9					1	141,559.9				
Дүн	4	209,946.1	1	172.4			3	209,773.7	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			